

Үндэсний статистикийн хорооны
дарга, Нийгмийн хамгаалал,
хөдөлмөрийн сайдын 2009 оны 6
дугаар сарын 19, 16-ны өдрийн
01/68/94 тоот тушаалын
хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

**УЛААНБААТАР ХОТ
2009 ОН**

ГАРЧИГ

Товчилсон үгийн жагсаалт

Нэг. Нийтлэг үндэслэл

Хоёр. Ойлголт, тодорхойлолт

Гурав. Үзүүлэлтийг тооцох арга зүй

Ашигласан материал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
НХХЯ	Нийгмийн Хамгаалал, Хөдөлмөрийн Яам
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Улсын хэмжээнд хүн амын хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний мэдээ, тайлан гаргаж, судалгаа явуулан, холбогдох үндсэн үзүүлэлтийг тооцоход энэхүү аргачлалыг ашиглана.

Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистикийн үзүүлэлтийг тооцох аргачлалыг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас гаргасан стандарт ойлголт, тодорхойлолтод нийцүүлэн, өөрийн орны онцлогийг тусган боловсруулав.

ХОЁР. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

2.1 “Эдийн засгийн үйл ажиллагаа”-нд зах зээлд болон хувийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бараа, үйлчилгээг хамруулна. Үндэсний тооцооны системийн хүрээнд бараа, үйлчилгээнд худалдах, солилцох, өөрийн аж ахуйд хэрэглэх зорилгоор боловсруулсан түүхий эд материал, зах зээлд нийлүүлж байгаа бүхий л бүтээгдэхүүн, үйлчилгээ, зах зээлд худалдах, өөртөө хэрэглэх зорилгоор өрхөд үйлдвэрлэж байгаа бараа, үйлчилгээг хамруулна.

2.1.1 “Эдийн засгийн үйл ажиллагааны албан салбар”-т Үндэсний тооцооны системийн хүрээнд албан ёсны бүртгэлд бүрэн хамрагдан хуулийн этгээдийн хяналтан дор эсвэл хуулийн этгээд болж тодорхой цаг хугацаанд зах зээлд худалдах, өөртөө хэрэглэхэд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хамруулна.

2.1.2 “Эдийн засгийн үйл ажиллагааны албан бус салбар”-т албан ёсны бүртгэл, мэдээлэл, татварт бүрэн хамрагддаггүй, орлогыг нь тодорхойлоход бэрхшээлтэй хэдий ч орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хамруулна.

2.2 “Эдийн засгийн бус үйл ажиллагаа”-нд хүүхэд, өндөр настан асрах, гэр цэвэрлэх, хоол унд бэлтгэх зэрэг цалин хөлс, орлого олохгүй үйл ажиллагааг хамруулна.

2.3. “Хөдөлмөрийн насны хүн ам”-д “Хөдөлмөрийн тухай” Монгол Улсын хуульд заасны дагуу 15-59 насны хүн амыг хамруулна (Хөдөлмөрийн тухай хуулийн 40.1.3, 109.2 дахь заалт).

2.4. “Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүн ам”-д хөдөлмөрийн чадвартай хүн ам, хөдөлмөрийн чадвараа хэсэгчлэн алдсан боловч түр хугацааны (зургаан сарын дотор) дараа нөхөн сэргээгдэх боломжтой хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна (“Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох, жагсаалтыг шинэчлэн батлах тухай” ЭМ-ийн сайд, НХХ-ийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 274/137 тоот хамтарсан тушаал).

2.5. “Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадваргүй хүн ам”-д хөдөлмөрийн чадвараа байнга буюу удаан хугацаагаар бүрэн болон хэсэгчлэн алдсан бөгөөд алдагдсан хөдөлмөрийн чадвар нь нөхөн сэргээгдэх боломжгүй хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

2.5.1 “Хөдөлмөрийн чадваргүй боловч хөдөлмөрлөх боломжтой хөдөлмөрийн насны, хүн ам”-д тухайн хугацааны үндсэн үйл ажиллагааных нь байдлаар эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогдож, цалин хөлс, орлого олж буй хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хамруулна.

2.6. “Хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам”-д хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай боловч хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй хүн амыг хамруулна.

2.7. “Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)”-д Үндэсний тооцооны системийн хүрээнд, тухайн цаг хугацаанд бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэдийг хамруулна. Эдийн засгийн идэвхтэй хүн ам (ажиллах хүч)-ыг эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам гэж хоёр ангилна.

2.7.1. “Эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам”-д урт хугацаагаар буюу сүүлийн арван хоёр сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

2.7.2. “Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам”-д сүүлийн долоо хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаараа ажиллаж байсан болон ажилгүй байсан нь тодорхойлогдох ажиллагч болон ажилгүй иргэдийг хамруулна.

2.8. “Үндсэн үйл ажиллагаа” гэж тухайн хүн хоёр болон түүнээс дээш төрлийн ажлыг хөлсөөр болон хувиараа эрхэлж байгаа бол тухайн хугацаанд хамгийн их цаг зарцуулсан эсхүл хамгийн их орлого олсон ажлыг хэлнэ.

2.9. “Эдийн засгийн идэвхгүй хүн ам”-д эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарагдахгүй хөдөлмөрийн насны нийт хүн ам болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн ам, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амд хөдөлмөрийн нөхцөл, онцлогоос шалтгаалан тэтгэврийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгосон хүн ам, хөдөлмөрийн чадвараа зургаан сараас дээш хугацаагаар түр болон бүрэн алдсан иргэн, хөдөлмөрийн насны өдрөөр суралцагч, хүндэтгэх ба хүндэтгэх бус шалтгаанаар хөдөлмөр эрхлээгүй болон хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амыг хамруулна. Эдийн засгийн идэвхгүй хүн амыг эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам, эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам гэж хоёр ангилна.

2.9.1 “Эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам”-д урт хугацаагаар буюу сүүлийн арван хоёр сарын хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагаагаараа эдийн засгийн идэвхтэй хүн амд тооцогдохгүй (ажиллагч болон ажилгүй иргэнд хамаарахгүй) хүн амыг, тухайлбал оюутан, сурагч, гэрийн ажилтай болон өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хүн амыг хамруулна.

2.9.2 “Эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам”-д сүүлийн долоо хоногт сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон болон өндөр настай, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллагч болон ажилгүй иргэдийн алинд ч хамаарахгүй хүн амыг хамруулна.

2.10. “Гэрийн ажилтай хүн ам”-д хүүхэд, өндөр настан, өвчтөн асардаг, гэр бүлийн хүний ажлын онцлогоос шалтгаалан хөдөлмөр эрхлээгүй зэрэг тухайн хугацааны үндсэн үйл ажиллагаа нь эдийн засгийн бус үйл ажиллагаанд тооцогдож буй хөдөлмөрийн насны хүн амыг хамруулна.

2.11. “Хөдөлмөрийн насны суралцагч” гэж бүх шатны сургууль (их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв/зургаан сараас дээш хугацаагаар сурч буй/ болон ЕБС)-д суралцаж буй хөдөлмөрийн насны иргэнийг хэлнэ.

2.12. “Ажиллагч” гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлтийн аль нэг статуст хамрагдаж буй иргэнийг хэлнэ. Цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд сүүлийн долоо хоногт нэгээс дээш цагаар оролцсон бол ажиллагч гэж үзнэ.

2.12.1. “Цалин хөлстэй ажиллагч”-д хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг хамруулна.

2.12.1.1. “Байнгын ажилтан” гэж байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн тухай болон төрийн албаны тухай хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хэлнэ (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 3.1.15.).

2.12.1.1.1. “Албан ажлаа түр эрхлээгүй байгаа байнгын ажилтан”-д ээлжийн амралтаа авсан, ажил хаясан, үйлдвэрлэлийн сул зогсолт гарч байгууллагын эдийн засгийн үйл ажиллагаа түр хугацаагаар тасалдсан болон зургаан сар хүртэлх хугацаагаар өвчтэй байсан, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, суралцах, жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй зэрэг шалтгаанаар ажлаа хийгээгүй боловч хөдөлмөрийн гэрээ цуцлаагүй бөгөөд ажлын байр нь хадгалагдаж байгаа эргэн ажиллах, байнгын ажлын байранд албан ёсны гэрээтэй иргэнийг хамруулна.

2.12.1.1.2. “Улирлын ажилтан”-д улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг иргэнийг хамруулна.

2.12.1.2. “Түр ажилтан”-д хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн болон иргэний хуулиар зохицуулагддаг тодорхой ажил, үйлчилгээг хөдөлмөрийн ба хөлсөөр ажиллах, ажил гүйцэтгэх гэрээг үйл ажиллагааны онцлогоос хамааран зургаан сар хүртэлх хугацаагаар байгуулж, цалин хөлс, орлого олдог, эдийн засгийн идэвхтэй хүн амд хамаарах, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг өөрөө бие даан хариуцаж төлдөг иргэнийг хамруулна (Цагийн ажил хийж буй хөдөлмөрийн насны суралцагчийг хамруулахгүй).

2.12.1.3. “Бүрэн бус цагаар ажиллагч”-д хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулиар зохицуулагддаг боловч долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэлээс бага хугацаагаар ажиллаж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон өөрөө хариуцан төлдөг иргэнийг хамруулна (Үүнд: цагийн ажил хийж буй хөдөлмөрийн насны суралцагчийг хамруулахгүй). Ажиллах хэлбэр, цагийг харгалзан бүрэн бус хөдөлмөр эрхлэлтэд хамааруулна (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 70.1.).

2.12.1.4. “Гэрээт ажиллагч”-д ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс, урамшуулал авдаг 2.12.1.1-д хамаарахгүй иргэнийг хамруулна (“Иргэний тухай” хуулийн 359 дүгээр зүйл).

2.13. “Албан бус хөдөлмөр эрхлэгч”-д албан ёсны бүртгэл, нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй, аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй, хөдөө аж ахуйн бус бөгөөд хуулиар хориглоогүй ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэдийг хамруулна.

2.13.1. “Албан ёсны хөдөлмөр эрхлэлтийн бүртгэлд бүрэн хамрагдаагүй иргэн” гэж хөдөлмөр эрхлэлтийн статистик болон захиргааны бүртгэл, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн орлогын албан татварын талаарх мэдээлэлд хамрагдаагүй иргэнийг хэлнэ.

2.13.2. “Нийгмийн хамгаалалд бүрэн хамрагдаагүй” гэдэгт “Нийгмийн даатгалын тухай” Монгол Улсын хуулийн холбогдох заалтын дагуу тэтгэвэр, тэтгэмж, эрүүл мэнд, ажилгүйдэл, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалд хамрагдаагүй хүн ам багтана.

2.13.3. “Хөдөө аж ахуйн бус ажил, үйлчилгээ”-нд газар тариалан, ойн аж ахуй, мал аж ахуй, шавьж үржүүлгийн ажил, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт, хадгалалт, үйлдвэрлэлт, тээвэрлэлт, хөдөө аж ахуйн машин, техникийн ашиглалт, засвар үйлчилгээнээс бусад ажил үйлчилгээг хамруулна.

2.13.4. “Аж ахуй эрхлэх зохион байгуулалтын хэлбэрт ороогүй” гэж холбогдох хуулийн дагуу хоршоо, нөхөрлөл, компанийн хэлбэрээр аж ахуй эрхэлдэггүй, өрхийн нэг гишүүн эсвэл түүнээс дээш тооны өрхийн гишүүний эзэмшилд байдаг, тухайн өрх дангаараа эсвэл бусад өрхтэй хамтран эзэмшдэг үйлдвэрлэлийнхээ зарим хэсгийг зах зээлд борлуулдаг (бараа солилцоо хийдэг), аж ахуйн зохион байгуулалтад ороогүй өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээний нэгжийг хэлнэ.

2.14. “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт”-д эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа 5-11 насны, хөнгөн ажлыг 7 хоногт 14-өөс дээш цагаар хийж байгаа 12-14 насны, 7 хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажиллаж байгаа 15-17 насны бүх хүүхдийг тус тус хамруулна.

2.15. “Ажлын байр” гэж эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд хөдөлмөр эрхлэлтийн статусын аль нэгэнд хамаарагдах ажил үүрэг, албан тушаалыг хэлнэ.

2.15.1. “Ажлын шинэ байр” гэж эдийн засгийн үйл ажиллагааны хүрээнд үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох болон өргөтгөх замаар албан ба албан бус салбарт шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ. Ажиллагчдын шилжилт хөдөлгөөн, тухайлбал ажилтан тэтгэвэрт гарсны дараа орных нь хүнийг авах, ажлын байр/орон тоо шилжих, нэгтгэн зохион байгуулах зэрэг тохиолдлыг ажлын шинэ байранд тооцохгүй.

2.15.1.1. “Байнгын ажлын шинэ байр” гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор, баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ (“Хөдөлмөрийн тухай” хуулийн 3.1.15.).

2.15.1.2. “Улирлын ажлын шинэ байр” гэж улирлын чанартай байнгын ажлын байранд ажиллах албан ёсны гэрээтэй бөгөөд ажил олгогч нь татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийг хариуцан төлдөг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжоор зохицуулагддаг, шинээр бий болсон ажил, үүрэг, албан тушаалыг хэлнэ.

2.16. “Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт”-д тухайн хугацааны үндсэн үйл ажиллагаандаа ажлын цагийн тогтоосон доод хязгаараас бага цагаар ажилладаг эсхүл нэмэлт цагаар ажиллах хүсэлтэй бөгөөд ажиллахад бэлэн байгаа түүнчлэн тухайн хүний эзэмшсэн мэргэжил ур чадварыг бүрэн ашиглахгүй, бүтээмж доогуур байхыг хамруулна. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт нь ил, далд гэсэн хоёр хэлбэртэй байна.

2.16.1. “Бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн ил хэлбэр” гэдэг нь цалин хөлс, орлоготой хөдөлмөр эрхэлдэг боловч нэмэлт цагаар ажиллах хүсэлтэй, ажиллахад бэлэн, ажлын өдөр, цагийн тогтоосон доод хязгаараас бага цагаар ажиллаж байгаа цаг хугацаагаар хэмжигдэх хөдөлмөр эрхлэлтийг бүрэн бус хөдөлмөр эрхлэлт гэж нэрлэнэ.

2.16.2. “Бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийн далд хэлбэр” нь тухайн хүний эзэмшсэн мэргэжил ур чадвар бүрэн ашиглагдахгүй ажил эрхэлж байгаа нөхцлийг хэлнэ. Энэхүү хэлбэр нь эдийн засгийн үйл ажиллагаанаас олж буй орлого бага, бүтээмж доогуур, тухайн хүний эзэмшсэн мэргэжил, ур чадвар гүйцэтгэж буй ажилтайгаа зохицоогүй зэргээр тодорхойлогдоно.

2.17. “Хөдөлмөр эрхлэлтийн статус” гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн хүний ажиллаж байгаа байгууллага, бусад хүмүүстэй харьцах эрх мэдэл, ажил үүрэг, хүлээх хариуцлагаар тодорхойлогдоно.

2.17.1. “Цалин хөлстэй ажиллагч” гэж хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан эсхүл аман гэрээ болон хоёр талын тохиролцоогоор ажилладаг, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай хууль, Иргэний хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор

зохицуулагддаг, ажил олгогчдод ажил, үйлчилгээ үзүүлснийхээ төлөө мөнгөн ба мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг иргэнийг хэлнэ.

2.17.2. “Ажил олгогч” гэж эдийн засгийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг бие даан гаргаж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээнээс олсон ашиг буюу ашиг олох боломжоос шууд хамаарах бизнестээ урт хугацаагаар нэг буюу түүнээс дээш ажилтныг хөдөлмөрийн болон бусад гэрээ, тохиролцооны үндсэн дээр авч ажиллуулж буй эзэн, байгууллагын удирдлагыг хэлнэ.

2.17.3. “Хувиараа хөдөлмөр эрхлэгч” гэж дангаараа буюу бусадтай хамтран өөрийн багаж, тоног төхөөрөмж, бусад материалыг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг хараат бусаар явуулж, урт хугацаагаар ажилтан авч ажиллуулдаггүй (харин богино хугацаагаар түр авч ажиллуулж болно), бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрийг бие даан гаргадаг иргэнийг хэлнэ.

2.17.4. “Нөхөрлөл, хоршооны гишүүн” гэж үйлдвэрлэл, үйлчилгээний нөхөрлөл, хоршоонд өөрийн эд хөрөнгө, хөдөлмөрөө сайн дураар нэгтгэж гишүүнээр элссэн, үйлдвэрлэл, борлуулалт зэрэг байгууллагын бусад ажлын зохион байгуулалт, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон гишүүдийн дунд ашиг хуваарилах асуудлыг шийдвэрлэхэд бусад гишүүдтэй адил тэгш оролцдог иргэнийг хэлнэ.

2.17.5. “Мал аж ахуй эрхлэгч” гэж жилийн дөрвөн улирлын туршид өөрийн мал аж ахуйг эрхэлж, түүний бүтээгдэхүүн, ашиг шимээр орлого олж, амьжиргааны эх үүсвэрээ хангаж буй иргэнийг хэлнэ.

2.17.6. “Өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч” гэж мал аж ахуйгаас бусад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд цалин хөлсгүй оролцон, хувийн хэрэглээгээ хангаж буй тухайн өрхийн гишүүн болон тухайн өрхөд хамт амьдрахгүйгээр аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд нь оролцож байгаа иргэнийг хэлнэ.

2.17.7. “Эдгээр статуст хамрагдах боломжгүй ажиллагч” гэж тэдний талаар зохих мэдээлэл хангалтгүй эсхүл дээр дурьдсан статусын аль нэгэнд хамаарах боломжгүй иргэнийг хэлнэ.

2.18. “Ажил хайгч” гэж ажилгүй эсхүл ажилтай боловч ажлын нөхцлөө сайжруулах, нэмэлт орлого олох зорилгоор ажил хайж байгаа иргэнийг хэлнэ.

2.18.1. “Ажилгүй иргэн” гэж тухайн хугацаанд ажилгүй байсан, ажил хийхэд бэлэн, ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай иргэнийг хэлнэ.

а/ “ажилгүй байсан” гэж сүүлийн долоо хоногт Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр болон ажил гүйцэтгэх гэрээгээр ямар нэг ажил гүйцэтгээгүй, хувиараа ажил, үйлчилгээ эрхэлж орлого олоогүй байхыг;

б/ “ажил хийхэд бэлэн” гэж Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулийн 359 дүгээр зүйлд заасан хөлсөөр ажиллах болон ажил гүйцэтгэх гэрээ байгуулахаас татгалзахгүй байхыг;

в/ “ажил идэвхтэй хайж байгаа” гэж ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлж, нэгээс доошгүй удаа ажлын байрны талаар мэдээлэл авсан эсхүл ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих зэрэг ажил олох оролдлого идэвхтэй хийснийг тус тус ойлгоно.

2.19. “Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэн” гэж зургаан сар буюу түүнээс дээш хугацаагаар хөдөлмөр эрхлээгүй, ажилгүй иргэнийг хэлнэ.

2.20. “Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн” гэж хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл хүлээн авсан, эрүүл мэндийн шалтгаанаар ажлаа солих шаардлагатай болсон, эрхэлж байсан мал аж ахуй, газар тариалан, хувийн аж ахуй нь эрсдэлд орсны улмаас эдийн засгийн үйл ажиллагаа эрхлэн орлого олох боломжгүй болж болзошгүй тухайгаа хөдөлмөр зуучлалын төрийн болон хувийн байгууллагад мэдэгдэж бүртгүүлсэн иргэнийг хэлнэ.

ГУРАВ. ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТООЦОХ АРГА ЗҮЙ

3.1 Хөдөлмөр эрхлэлт болон ажиллах хүчний статистикийн дараах үзүүлэлтийг тооцож гаргана. Үүнд:

3.1.1. **Хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай хүн ам:** Хөдөлмөрийн насны нийт хүн амаас хөдөлмөрийн чадваргүй, хөдөлмөрийн насны хүн амыг хасч тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.2. **Эдийн засгийн идэвхтэй хүн ам:** Хөдөлмөрийн насны, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагч, нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй иргэн, хөдөлмөрийн насанд хүрээгүй болон хөдөлмөрийн наснаас дээш насны эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож байгаа хүн амын тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.3. **Эдийн засгийн байнгын идэвхтэй хүн ам:** Урт хугацаагаар буюу сүүлийн 12 сарын хугацаанд эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаар ажиллаж байсан болон ажилгүй байсан хөдөлмөрийн насны хүн амын тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.4. **Эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн ам:** Ажиллаж байсан болон ажилгүй байсан нь сүүлийн 7 хоногт эрхэлсэн үндсэн үйл ажиллагааны шинж байдлаар тодорхойлогдож байгаа ажиллагч болон ажилгүй иргэдийн тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.5. **Ажиллах хүчний оролцооны түвшин:** Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\begin{aligned} \text{Ажиллах хүчний оролцооны түвшин} &= \\ &= \frac{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100 \end{aligned}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.6. **Хөдөлмөр эрхлэлтийн түвшин:** Ажиллагчдын тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчдын тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.7. Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажилгүйдлийн түвшин} = \frac{\text{Ажилгүй иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.8. Урт хугацааны ажилгүйдлийн түвшин: Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэдийн тоог эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\begin{aligned} \text{Урт хугацааны ажилгүйдлийн түвшин} &= \\ &= \frac{\text{Урт хугацаагаар ажилгүй байгаа иргэдийн тоо}}{\text{Эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100 \end{aligned}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.9. Залуучуудын ажилгүйдлийн түвшин: 15-24 насны ажилгүй иргэдийн тоог 15-24 насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\begin{aligned} \text{Залуучуудын ажилгүйдлийн түвшин} &= \\ &= \frac{15 - 24 \text{ насны ажилгүй иргэдийн тоо}}{15 - 24 \text{ насны эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо}} \times 100 \end{aligned}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.10. Эдийн засгийн идэвхгүй хүн ам: Хөдөлмөрийн насны, эдийн засгийн идэвхтэй хүн ам буюу ажиллах хүчинд хамаарагдахгүй хүн амын тоо, эдийн засгийн идэвхтэй үйл ажиллагаанд оролцдоггүй, хөдөлмөрийн насанд хүрээгүй хүн амын тоо, хөдөлмөрийн наснаас дээш насны хүн амын тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.11. Эдийн засгийн байнгын идэвхгүй хүн ам: Нийт хүн амын тооноос эдийн засгийн байнгын идэвхтэй хүн амын тоог хасч тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.12. Эдийн засгийн тухайн үеийн идэвхгүй хүн ам: Нийт хүн амын тооноос эдийн засгийн тухайн үеийн идэвхтэй хүн амын тоог хасч тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.13. Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин: Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\begin{aligned} \text{Эдийн засгийн идэвхгүй байдлын түвшин} &= \\ &= \frac{\text{Эдийн засгийн идэвхгүй хүн амын тоо}}{\text{Хөдөлмөрийн насны хүн амын тоо}} \times 100 \end{aligned}$$

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.14. Хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлээгүй хөдөлмөрийн насны хүн ам: Хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөрийн насны хүн амын тооноос эдийн засгийн идэвхтэй хүн амын тоо, хөдөлмөрийн наснаас өмнө тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авч буй, эдийн засгийн үйл ажиллагаанд оролцоогүй хүн амын тоог хасч тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.15. Бүрэн бус хөдөлмөр эрхлэлт: Нэмэлт цагаар ажиллах хүсэлтэй, цагаар ажиллагч болон ажилтай боловч нэмэлт ажил хайж буй хөдөлмөр эрхлэгчийн нийлбэрээр ил хэлбэрийн бүрэн бус хөдөлмөр эрхлэлтийг тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүнгээс, улирал бүр

3.1.16. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн тоо: Эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж буй 5-11 насны бүх хүүхэд, хөнгөн ажлыг 7 хоногт 14-өөс дээш цагаар хийж байгаа 12-14 насны хүүхэд, долоо хоногт 43 ба түүнээс дээш цагаар ажил эрхэлж байгаа 15-17 насны хүүхдийн тооны нийлбэрээр тооцно.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Хүүхдийн хөдөлмөрийн судалгаа”-ны үр дүнгээс, тухай бүр

3.1.17. Хөдөлмөрийн бүтээмж: Нэгж хөдөлмөрийн (хөдөлмөр эрхэлж буй хүн ам буюу ажиллагчид) орцод ногдох гарцын хэмжээгээр тодорхойлно. Өөрөөр хэлбэл нэгж ажиллагчид ногдох ДНБ (нэмэгдэл өртөг)-ний хэмжээгээр тодорхойлно (Бүтээмжийн аргачлал).

Хөдөлмөрийн бүтээмжийг дараах томъёогоор тооцно.

$$P = \frac{Y}{N}$$

P—Хөдөлмөрийн бүтээмж

эрхлэлтийн мэдрэмж нь 0.6 байвал ажиллагчдын жилийн дундаж өсөлт 1.2 хувь, харин бүтээмжийн хувьд 0.8 хувь байна.

- $\epsilon > 1$ байх үеийн ДНБ-ий өсөлт эерэг/+ үед ажиллагчдын тооны жилийн дундаж өсөлт эерэг, бүтээмжийн өсөлт сөрөг байхыг харуулж байна.
- $\epsilon > 1$ байх үеийн ДНБ-ий өсөлт сөрөг/- үед ажиллагчдын тооны жилийн дундаж өсөлт сөрөг, бүтээмжийн өсөлт эерэг байхыг харуулж байна.

Мэдээллийн эх үүсвэр, давтамж: ҮСХ-ны “Ажиллах хүчний судалгаа”-ны үр дүн, Монгол Улсын статистикийн эмхтгэл, жил бүр

..... о О о

Ашигласан материал

- Хөдөлмөрийн тухай
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиуд
- Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлого
- "Монгол Улсын хөдөлмөрийн статистикийн талаарх судалгаа"-ны тайлан, Барт де Бруин, Улаанбаатар, Монгол улс, 2008.11.21-12.12
- Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (ОУХБ)-аас гаргасан стандарт ойлголт, тодорхойлолт
- ОУХБ-ын Хөдөлмөрийн зах зээлийн ундсэн үзүүлэлтүүд (ХЗЗҮҮ)
- Зохистой хөдөлмөрийн үзүүлэлтүүд (ЗХҮ)
- Олон улсын хөдөлмөрийн статистикчдын бага хурлуудын зөвлөмжүүд
- <http://www.ilo.org/>

Хавсралт 1

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, АЖИЛЛАХ ХҮЧНИЙ СТАТИСТИКИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БҮДҮҮВЧ

